

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2024/4

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.IV	2023.IV	2024.III	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2024 оны 1-р улирал	их наяд ₮, оны үнээр	-	13.6	16.5	-	-	-	7.8% ▲
Инфляц	хувь	6.4	11.3	7.0	0.8% ▲	-	3.3% ▲	-4.9 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин	хувь	3.9% 2024 оны У4	5.3% 2022 оны У4	3.9% 2023 оны У4	-	-1.3% ▼ нэгж хувиар	-	-1.4% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	2134	1100	1626	507 ▲	-	-	1034 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3376.53	3496.41	3376.22	0.31 ▲	-	-	-119.88 ▼
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	1510.9	2423.4	1244.6	-	-	-	-913 ▼
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	24.4	19.6	17.7	-	-	-	4.8 ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	499.4	483.3	367.4	-	-	-	16.1 ▲
Төв банкны бодлогын хүү	хувь	12%	13%	12%	0%	-	0%	-1%
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	4.99	3.69	5.25	-5.03% ▼	-	-	35.06% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	6.83%	9.66%	7.06%	-0.24 нэгж хувиар ▼	-	-	-2.83 нэгж хувиар ▼

ОНЦЛОХ СТАТИСТИК:

"Хар жагсаалт"-ад байгаа ААН, иргэдийг "өршөөлөө"	Монголбанкнаас гаргасан шийдвэр нь 2024 оны дөрөвдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байгаа бөгөөд анхаарал хандуулах (хугацаа хэтэрсэн) болон чанаргүй зээлийн ангилалд орсон зээл, өр төлбөрөө 2024 оны зургаадугаар сарын 2-ны өдөрт багтаан бүрэн барагдуулсан тохиолдолд дээрх арга хэмжээнд мөн хамрагдах боломжийг иргэн, аж ахуйн нэгжид давхар олгож байна.
---	---

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Үндэсний баялагийн сангийн тухай хуулийг баталлаа.	2024/04/19	Энэ хуулийн зорилт нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор Үндэсний баялгийн санг байгуулах, түүний төрөл, зориулалт, эх үүсвэрийг тодорхойлох, сангийн хөрөнгийн тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааг тайлагнах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График


Нөлөөлөл

Инфляц




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 6.4 хувь, өмнөх оны эцсээс 3.3 хувь, өмнөх сараас 0.8 хувиар өссөн байна. Улсын инфляцад бензин, түлшнээс бусад импортын барааны үнэ 2.2 нэгж хувиар (34.8%), мах, хатуу түлшнээс бусад дотоодын барааны үнэ 3.3 нэгж хувиар (51.8%) тус тус нөлөөлсөн байна.

Валютын ханш




Америк долларын ханш 2024 оны 4 дүгээр сард 3376.53 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 119.88 төгрөгөөр суларч, өмнөх сараас 0.31 төгрөгөөр тус тус чангарсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас -5.03% бүүрч, өнгөрсөн жилийн мөн үеэс 35.06%-р тус тус өсөж, 4.99 тэрбум ам.долларт хүрэв.

Улсын төсөв



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2024 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 10.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.2 (44.5%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 9.9 их наяд төгрөгт хүрч, 3.2 (47.8%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2024 оны эхний 4 сард 7.8 их наяд төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн тэнцэл 2.1 их наяд төгрөгийн ашигтай гарчээ.

Гадаад худалдаа



Монгол Улс 2024 оны эхний 4 сард нийт 139 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 8.4 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 4.9 тэрбум ам.доллар, импорт 3.4 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарчээ. Экспорт 2024 оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 148.6 сая ам.доллаароор буурахад нүүрс 89.1 сая ам.доллар, цайрын хүдэр, баяжмал 72.3 сая ам.доллар, лаазалсан махан бүтээгдэхүүн 41.8 сая ам.доллар, адууны мах 34.5 сая ам.доллаароор тус тус бүүрсан нь голлон нөлөөлжээ. Харин боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 85.3 сая ам.доллар, төмрийн хүдэр, баяжмал 39.0 сая ам.доллаароор тус тус өссөн байна.

Дэлхийн эдийн засагт

- 2024 онд Монгол Улсын эдийн засаг 5.9 хувь өснө. Эх үүсвэр: Азийн хөгжлийн банк
- Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийг 6.2% өснө гэж таамаглажээ.
- БНХАУ-ын эдийн засаг 2023 онд 5.2% өсөв.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 4-р сар 2024 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 4-р сар 2024 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn